

**Засгийн газрын үйл ажиллагааны
2004 оны эхний хагас жилийн товч мэдээлэл**
/2004.01.01.-2004.06.25./

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журмыг УИХ-ын тогтоолоор батлуулав. Энэхүү журам батлагдсанаар Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулга, түүнийг боловсруулах үйл явц, хугацаа, нийтлэг загвар болон оролцогч талуудын үүрэг, хариуцлага тодорхой болов.

2004 оны эхний хагас жилд Засгийн газар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд дэвшүүлэн тавьсан үндсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна. Үүнд:

- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх, аж үйлдвэр, газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, мөнгө, санхүүгийн тогтвортой байдлыг бататгах бодлого явуулах замаар дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2004 онд 6,0 хувьд хүргэнэ.
- Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өсөлтийг 5,4 хувьд хүргэнэ.
- Бүсчилсэн хөгжлийн зорилтыг хот, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлоготой холбон уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлэх зохион байгуулалтын үндсийг бүрдүүлнэ.
- Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хүрээнд хүний хөгжлийг хангах орчныг бүрдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг сайжруулна.
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлийг улс орны болон дэлхий дахины нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулна.

Эдгээр үндсэн зорилтын хүрээнд Засгийн газраас 2004 онд Монголд зочлох жилийг үргэлжлүүлэх, 2004 оныг “Усны бодлогын шинэтгэлийн жил”, “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” болгон тус тус зарлав. Дээр дурдсан үндсэн зорилтын хүрээнд энэ оны эхний хагас жилд үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мал өвөлжилт, хаваржилт болон цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллав.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 314 зорилтын биелэлт 98,3 хувь, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 98,0 хувьтай байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийгмийн бодлогын зорилтууд бүрэн биелсэн байна. Макро эдийн засгийн тогтворжилтыг хангах, банк, санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг сэргээх, дэд бүтцийг бүс нутгаар хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар тавьсан зорилтууд амжилттай хэрэгжиж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2004 оны эхний 5 сарын төсвийн гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн нийт орлого 248.7 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 21.3 хувиар давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 65.0 тэрбум төгрөгөөр буюу 35.4 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага 250.1 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн нийт зарлагын 92.6 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 20.9 хувиар өссөн байна. Эхний 5 сарын байдлаар төсвийн урсгал тэнцэл (өссөн дүнгээр) 37.0 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 1.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Засгийн газраас эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн

өртгийн татвар, Гаалийн тарифын болон Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулиудад нэмэлт оруулах тухай, Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцийн нэмэлт, өөрчлөлтөд хамаарах Монреалын Протоколыг соёрхон батлах тухай, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн барив.

Засгийн газраас “Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Төрийн өндөр албан тушаалын болон түүнтэй адилтгах албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай”, “Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай”, Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай УИХ-ын тогтоолын төслүүдийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэв.

Улсын хэмжээнд архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын үзлэг явагдаж, нийт яам, газар амжилттай дүн үзүүлэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын ажлын албаны хувьд Засгийн газрын шийдвэрийг хянан боловсруулах, хэрэгжүүлэх, Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын харилцан ажиллагааг зохицуулахад туслах, хүний нөөцийн удирдлага, нийтлэг үйлчилгээний удирдлагаар хангах асуудлыг эрхлэн гүйцэтгэж байна.

Төрийн өмчийг 2004 онд хувьчлах хөтөлбөр батлах тухай болон Хууль тогтоомжид зохих зохицуулалт хийх хүртэл мэргэжлийн хяналтын байгууллагуудын чиглэлээр захиргааны журмаар хураасан эд зүйлийг улсын орлого болгох, устгах талаар шийдвэр гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дэргэдээ байгуулан ажиллуулах зөвшөөрлийг Улсын мэргэжлийн хяналтын газрын даргад олгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар тус тус хэлэлцэж тогтоол гарган хэрэгжүүлж эхлэв.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч болон УИХ-ын гишүүдээс санаачлан боловсруулж Засгийн газраас санал дүгнэлт авахаар ирүүлсэн Терроризмтэй тэмцэх тухай, Зэвсэгт хүчинд ажиллагч төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай, Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хууль болон Хилийн хуульд нэмэлт, оруулах тухай зэрэг нийт 10 хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт боловсруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, өөрсдийн саналыг тусган төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн гарсан шийдвэрийг хууль санаачлагчид хүргүүлсэн болно. Мөн яам, агентлагаас ирүүлсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн төсөл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт хөтлөх тухай журам, жагсаалт, гэрчилгээний загвар батлах тухай, Замын хөдөлгөөний дүрэм батлах тухай, Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн байрны тухай, Марубени корпорацитай холбоотой шүүхийн шийдвэрийн тухай, Архидан согтуурахтай тэмцэх сан байгуулах тухай, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай зэрэг 30 гаруй асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байна.

Засгийн газар Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулж, тус газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлав. Түүнчлэн “Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, гаргасан тогтоолоор аймаг, нийслэлийн Гамшгаас хамгаалах штабыг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд агентлагийн хэлбэрээр ажиллуулахаар шийдвэрлэсэн байна. Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагчийн сахилгын дүрмийг батлан гаргаж, мөрдүүлж байна.

2004 онд иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, тогтоол гаргав.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны зарим байгуулагад Засаглалын шинэчлэлийн матрицын дагуу Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилтийг танилцаж, үнэлгээ дүгнэлт өгч, цаашид анхаарах асуудлаар санал боловсруулан

ажиллав. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулиар олгогдсон бүрэн эрхээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежер, төсвийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн албаны төв байгууллага, төрийн аудитын төв байгууллагууд үндсэндээ хэрэгжүүлж байна. Танилцсан байдлаас үзвэл “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн хэрэгжилтийн явц “хангалттай” байна.

Монгол Улсын иргэд, төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөгчид, хандивлагчид хууль тогтоомжид саналаа өгөх боломж олгох зорилгоор байгуулсан “Нээлттэй засаг” ВЭБ сайттай хэрхэн ажилласан тухай Монгол Улсын сайд нар Ерөнхий сайдын баталсан хуваариар Засгийн газрын хуралдаанд 7 хоног бүр танилцуулж байна. Засгийн газраас тогтоосон журмын дагуу сайд нар ВЭБ сайтад ирсэн мэдээллийн хариуг латин үсгээр бичиж өгч байгаа бөгөөд олон нийтийн саналыг төр, засгийн бодлогод тусгах талаар анхаарч ажиллажээ.

Ерөнхий сайдын эрхлэх хүрээний 6 агентлагтай харилцах, хэлэлцүүлэхэд бэлтгэх, гэрээ, төлөвлөгөөг батлуулах, гүйцэтгэлд хяналт тавих 7 багц үйлчилгээг хэрэгжүүлсэн байна.

2003 оны 4 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын Их хурлын 34 тогтоолын 60 заалт, Ерөнхийлөгчийн 6 зарлигийн 6 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 19 зөвлөмжийн 45 заалтын хэрэгжилтийн явцад хяналт шинэжилгээ хийхэд Засгийн газарт холбогдох заалтын 48.8 хувь бүрэн биелсэн, нийт заалтын хэрэгжилтийн явц 86.4 хувьтай байлаа. 2004 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын Их хурлын 29 тогтоолын 48 заалт, Ерөнхийлөгчийн 6 зарлигийн 7 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 20 зөвлөмжийн 45 заалтын хэрэгжилтийн явцад хяналт шинэжилгээ хийхэд Засгийн газарт холбогдох заалтын 38.5 хувь нь бүрэн биелсэн, хэрэгжилтийн явц 84.1 хувьтай байлаа.

Монгол Улсын Их хурлын тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Ерөнхийлөгчийн зарлигуудын Засгийн газарт холбогдох заалтуудын хэрэгжилтийн явцын тайлан, мэдээллийг 2003 оны 4 дүгээр улирал, 2004 оны 1 дүгээр улирлын байдлаар тус тус Засгийн газрын шийдвэрийн төслийн хамт Хэрэг эрхлэх газрын дарга, дэд дарга нарт танилцуулан зөвшөөрөл авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар танилцуулан Засгийн газрын хуралдааны 7, 19 дугаар тэмдэглэлээр сайд, дарга нарт үүрэг болголоо.

Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад 2003 оны 4 дүгээр улирал, 2004 оны 1 дүгээр улирлын байдлаар хяналт шинэжилгээ үнэлгээ хийв

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц 314 зорилтоос 268 бүрэн биелсэн 46 зорилт үргэлжилэн хэрэгжиж 98.3 хувьтай байна.

Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа 87 хөтөлбөрийн хэрэгжилтийн явц яамдын дүнгээр 13 нь бүрэн хэрэгжиж 54 хөтөлбөр зохих ёсоор хэрэгжиж байгаа бөгөөд 69.9 хувьтай байна. Мөн түүнчлэн 4 хөтөлбөр удаашралтай, 9 хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа дууссан байдалтай байна.

Засгийн газрын үйл ажиллагааны 2004 оны 1, 2, 3, 4, 5 дугаар сарын мэдээллийг Ерөнхий сайд, ХЭГ-ын удирдлагад танилцуулж, 2004 оны 1 дүгээр улирлын мэдээллийг Засгийн газрын 4 дүгээр сарын 14-ны хуралдаанд танилцуулав.

1. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН БОДЛОГО

2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийг УИХ-ын тогтоолоор батлуулав. Энэхүү мэдэгдэлд төсвийн хүрээний үндсэн үзүүлэлтүүдийг ДНБ-д харьцуулсан хувиар: төсвийн нийт орлогын доод хэмжээг 41.4; төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 46.0; төсвийн урсгал тэнцлийн доод хэмжээг 7.1; төсвийн алдагдлын дээд хэмжээг -4.6; хөрөнгө оруулалтын зардлын дээд хэмжээг 5.9; төсөвт байгууллагад ажиллагчдын цалингийн нийт сангийн дээд хэмжээг 8.2 байхаар, ДНБ-ий бодит өсөлтийн доод хэмжээг 6.0 хувь, хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн дээд хэмжээг 5.0 хувиар тус тус зөвшөөрөв.

Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан Засаглалын шинэчлэлийн хөтөлбөрийн 2 дахь шатны болон Засаглалын шинэчлэлийн чадавхийг бэхжүүлэх техник, туслалцааны (15.5 сая ам.долларын хөнгөлөлттэй) зээлийн гэрээг УИХ-аар соёрхон батлуулав.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг УИХ-аар батлуулав. Энэхүү хуулиар янжуур тамхи үйлдвэрлэхэд зориулан түүхий эд хэлбэрээр импортлож буй задгай тамхи болон үйлдвэрлэсэн янжуур тамхинд онцгой албан татвар давхардуулан ногдуулж байсныг арилгах нэг алхам болов.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Захирагчдын зөвлөл банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Монгол Улсыг “Төв болон Зүүн Европын орнууд”-ын хүрээнд хамруулахаар шийдвэрлэсэн. Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай (2004-4-15) хуулийг УИХ-аар батлуулав. Ийнхүү тус банк манай улсыг санхүүжилт авах эрх бүхий улсын тоонд хамруулах зорилгоор суурь Хэлэлцээртээ өөрчлөлт оруулж буй нь Монгол Улсын хөгжлийн чиг хандлага, хамтын ажиллагааг ихээхэн дэмжиж, үнэлж буйн илрэл болж байна. Манай улс 2000 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч тус банкинд гишүүнээр элссэн боловч тухайн бүс нутагт нь үл хамаарах улс тул санхүүжилт авах эрх бүхий хүлээн авагч орны тоонд багтаагүй байсан юм.

Улсын төсвийн 2004 оны төлөвлөгөөг үндсэн мэдээллийн хэмжээнд аккруэл суурьт хөрвүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банкны хооронд байгуулсан Эрчим хүчний салбарын I хөтөлбөрийн нэмэлт зээлийн гэрээг соёрхон батлах тухай хуулийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулав. Энэхүү гэрээний дагуу 4.7 сая еврогийн зээлийн хөрөнгөөр Дарханы дулааны цахилгаан станцын зарим тоног төхөөрөмжийг шинэчлэхийн зэрэгцээ төвийн эрчим хүчний сүлжээний цахилгаан гүйдлийг хянах тоолуурын нэгдсэн тогтолцоо зэргийг сайжруулах болно.

Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичгийг УИХ-ын тогтоолоор батлуулав. Энэхүү стратегийн баримт бичигт төрийн албаны өнөөгийн байдалд үнэлгээ, дүгнэлт хийж, түүний үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулах, хариуцлага хүлээх чадварыг бэхжүүлэх чиглэлийг тусгасан байна.

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн нийгэмлэгийн хооронд Ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх 1 дэх зээлийн хэлэлцээний протоколыг үзэглэв.

Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, соёрхон батлуулахаар УИХ-д өргөн мэдүүлэхээр болов. Хэлэлцээрийг 1992 онд байгуулсан бөгөөд хэлэлцээрийн дагуу өнгөрсөн хугацаанд ХБНГУ-ын Засгийн газраас манай улсад нийт 90 гаруй сая еврогийн буцалтгүй тусламжийг үзүүлж, холбогдох төслүүдийг хэрэгжүүлсэн байна.

АХБ-наас 2004-2006 онд олгох зээл, тусламжийн тухай Харилцан ойлголцлын санамж бичигт Санхүү, эдийн засгийн сайд, АХБ-ны төлөөлөгч нар гарын үсэг зурав. Энэхүү санамж бичгийн дагуу АХБ-наас 2004-2006 онд 100 гаруй сая ам. долларын хөнгөлөлттэй зээл, 10 гаруй сая ам. долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр болов.

Монголын бизнес эрхлэгчдийн их чуулганы зөвлөмж, бизнес эрхлэгчдээс гаргасан саналыг хэрэгжүүлэх зорилгоор Бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолоор Бизнесийн таатай орчин бүрдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан мөрдүүлэв.

АНУ-ын Засгийн газраас 2004-2005 онд олгох 10 сая ам.долларын буцалтгүй тусламжийн тухай Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулж, гарын үсэг зурав.

Өрийн удирдлагын DMFAS-ийн мэдээллийн баазад 2004 оны эхний 6 сарын зээлийн ашиглалт, үндсэн болон хүүгийн буцаан төлбөрийг зээлдэгч санхүүгийн байгууллага, хандивлагч орон тус бүрээр оруулан шинэчлэв. Арилжааны банкуудаас Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу эхний 6 сард 4.6 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авлаа. Засгийн газар оны эхний 6 сарын байдлаар гадаад зээлийн үндсэн төлбөрт 10.5 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 8.4 тэрбум (бүгд 18.9 тэрбум) төгрөгийг төлсөн байна.

Улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг нөхөх зорилгоор 6 дугаар сард 5.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй Засгийн газрын хямдруулсан бондыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжиж, улсын төсөвт 4,8 тэрбум төгрөгийн эх үүсвэр

төвлөрүүлэв. Монголбанкинд байршиж байгаа өрийн бичгээс 2,0 тэрбум төгрөгийн өрийн бичгийг мөнгөжүүлэх арга хэмжээ авлаа.

Мянганы сорилтын сангийн үндэсний зөвлөлөөс эрхлэн “Мянганы сорилтын данс ба эдийн засгийн өсөлт” сэдэвт үндэсний анхны нээлттэй хэлэлцүүлгийг төрийн ба төрийн бус байгууллага, хувийн хэвшил, ард иргэдийн төлөөллийг оролцуулан өргөн хүрээнд зохион байгуулав. Мөн “Өнөөдөр” зэрэг сонинд үндэсний нээлттэй хэлэлцүүлгийг эхлээд байна.

Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг, Монгол Улсыг хариуцсан захирал манай улсад айлчлав. Тэрээр Монгол Улсын Ерөнхий сайдад бараалхаж, Санхүү, эдийн засгийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч нартай уулзав.

ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА

Монгол Улсад Ой модны салбар үүсч хөгжсөний 80 жил, Хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсч хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээг тус тус зохион байгуулсан байна. ЭКСПО-2005-д оролцох бүтээгдэхүүн шалгаруулах үзэсгэлэнг зохион байгуулав.

Ой, модны үйлдвэрлэлийг түшиглэн байгуулсан тосгоны талаар авах арга хэмжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд зориулан Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээл олгох тухай асуудлыг холбогдох аймгийн Засаг дарга нарт мэдэгдсэн байна.

“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийг барьж байгуулах, бүсийн үйл ажиллагааг менежментийн гэрээгээр гүйцэтгэх гадаадын хөрөнгө оруулагчдыг шалгаруулах журмын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн байршил, хилийн заагийг тогтоох тухай асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлээ. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн сан, мэргэжлийн хяналтын албаны орон тоог батлан ажиллуулж байна.

“Бөөний худалдаа сүлжээ” хөтөлбөрийн дагуу Дорнод, Өмнөговь аймагт энэ оны гуравдугаар сард Бөөний худалдааны сүлжээний нээлтийг хийв.

Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл, Монгол Улс, АНУ-тай байгуулах Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

Японы Жайка, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран “Монгол орны геологи, геоэкологийн асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгууллаа.

Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Израиль Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг тус тус Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн батлав.

БНСУ-ын зээл тусламжаар хэрэгжүүлэх төслийн хүрээнд “Зүүн бүсэд аж үйлдвэрийн парк байгуулах судалгаа”, “Жижиг, дунд үйлдвэрт шаардлагатай тоног төхөөрөмжийн лизинг”, Япон Улсын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх модны үйлдвэрлэлийн ноос, ноолуурын, арьс, ширний чиглэлээр төсөл боловсруулав.

Говь-Алтай, Баянхонгор аймгуудын нутгийн зарим хэсгийг хамарсан Замтын нурууны 3500 кв.км талбайд 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг Чехийн талтай хамтран хэрэгжүүлж эхлээд байна.

Чехийн Үйлдвэр, худалдааны яам, Монгол Улсын Үйлдвэр худалдааны яам хооронд, ХБНГУ-ын Эдийн засаг, хөдөлмөрийн яам, Монгол Улсын Үйлдвэр худалдааны яам хоорондын хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурлаа.

2. НИЙГМИЙН БОДЛОГО

Нийгмийн хамгааллын талаар авсан арга хэмжээ, үр дүн

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлаар Засгийн газрын тогтоол гарган 2004 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн бүрэн тэтгэврийн доод

хэмжээг 32000 төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 20000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон. Ингэснээр бүрэн тэтгэврийн доод хэмжээг 2003 оныхоос 41 хувиар, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 33,3 хувь нэмэгдүүлснээр дундаж тэтгэврийн хэмжээ 2003 оныхоос 31 хувиар, 2000 оны 1 дүгээр сард байсан дунджаас 2 гаруй дахин өсч, бүрэн ба хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 2000 оны түвшинээс 2 дахин нэмэгдэв.

Нийгмийн халамжийн сангаас олгох хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэн 12420 төгрөг болгож, энэ оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн тооцон олгож байна.

Төрийн захиргаа, төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ, жишгийг 2002-2003 оны инфляцийн түвшинтэй уялдуулан 7,5 хувь нэмэгдүүлэн тогтоож, тэдэнд ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгох журмыг батлан мөрдүүлэв. Энэ арга хэмжээнд 2004 онд төрийн албанд ажиллаж байгаа 121,2 мянган хүн хамрагдаж, тэдний цалин хөлс дунджаар 25,0 хувь нэмэгдэх бөгөөд улсын энэ оны төсөвт тусгагдсан 128,9 тэрбум төгрөгийн цалингийн санд багтаж хэрэгжих бололцоотой юм.

Улс төрийн албан тушаал эрхэлдэг баг, хороо, сум, дүүргийн Засаг даргын албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох асуудлыг Засгийн газрын тогтоолоор батлан мөрдөж байна. Энэ тогтоолоор сум, дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргын албан тушаалын цалинг тухайн шатны Засаг даргын албан тушаалын цалинтай адил байхаар тогтоож өгсөн юм.

2003-2012 оныг Ази, Номхон далайн бүсийн тахир дутуу иргэдийг дэмжих 10 жил болгон зарласантай холбогдуулан энэ ажлыг Монгол Улсад эрхлэн зохион байгуулах Үндэсний хороог байгуулж ажилд оруулав.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр тахир дутуу болж, хөдөлмөрийн чадвараа алдсан, харьяалах байгууллагагүйн улмаас хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу олгогдох нөхөн төлбөрөө авч чадахгүй хохирч байгаа 56 иргэнд 26 сая төгрөгийн нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэв.

Хүн амын бодлого, төсөв, хөрөнгө оруулалтын асуудлаар авсан арга хэмжээ

Засгийн газраас 2004 оныг “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан уг арга хэмжээний нээлтийг 2004 оны 1 дүгээр сард зохион байгуулав. “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөний дагуу Гэр бүлийн хөгжлийн төвийг байгуулан ажиллуулж байна. Гэр бүлийн хөгжлийн төв байгуулснаар гэр бүлд зөвлөлгөө өгөх, гэр бүлийн асуудлаар сургалт зохион байгуулах, мэдээллийн сүлжээ багйуулах зэрэг үйл ажиллагааг цогцоор зохион байгуулах боломжтой болох юм.

Монгол Улсын 16 нас хүрсэн иргэд андгай өргөх ёслолын ажиллагаа зохион байгуулах талаар Монголын залуучуудын холбооноос гаргасан санаачилгыг дэмжиж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн батлав. Андгай өргөх ёслолын ажиллагааг энэ оны 1 дүгээр сарын 13 буюу Монгол Улсын Үндсэн хуулийн баярын өдрийг тохиолдуулан анх удаа орон даяар зохион байгуулав.

Төрөөс “Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж батлуулав.

Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар авсан арга хэмжээ

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг инфляцийн түвшин, амьжиргааны түвшний өөрчлөлттэй уялдуулан шинэчлэн тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн 2004 оны 4 дүгээр тогтоолоор батлав. Уг тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2004 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн цагт 236 төгрөг 68 мөнгө буюу сард 40000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг 2004 оны 1 дүгээр сарын 16-наас эхлэн 32000 төгрөгт хүргэсэнтэй холбогдуулан нөхөн олговрын доод хэмжээг мөн ижил түвшинд нэмэгдүүлэв. Ингэснээр нөхөн олговрын доод хэмжээ 1999 оны түвшинээс 2,9 дахин нэмэгдлээ.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжил-арга зүйн төв”-ийг “Нийгмийн хамгааллын салбарын хөгжил хөтөлбөр” төслийн дэмжлэгтэйгээр байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2002-2003 оны гурван талт улсын хэлэлцээрийн 53 заалтын биелэлтийг нийгмийн түншлэгч талуудыг оролцуулан зөвшилцлийн зарчмаар дүгнэв. Хэлэлцээрийн нийт заалт 93,5 хувийн биелэлттэй дүгнэгдэв.

“Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хийсэн ажлын үр дүн” сэдэвт хэвлэлийн бага хурлыг зохион байгуулав. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээний сүүлийн 4 жилийн үр дүнгээс харвал өмнөх Засгийн газрын үеийнхтэй харьцуулвал ажлын байрны тоо 1,6 дахин, ажилд зуучлан оруулсан хүний тоо 1,9 дахин, мэргэжлийн сургалтанд хамрагдсан хүний тоо 3,8 дахин тус тус нэмэгдсэн байна.

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн банкны 18,6 сая ам.долларын хөнгөлттэй зээлээр “Тогтвортой амьжиргаа” төсөл Баян-өлгий, увс, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Өмнө-говь, Дорнод аймагт, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх Олон улсын сангийн 16,6 сая ам.долларын хөнгөлттэй зээлээр “Хөдөөгийн ядуурлыг тогтвортой бууруулах” төслийг Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий аймагт тус тус хэрэгжүүлээд байна.

БОЛОВСРОЛ

Бага, дунд боловсролын талаар

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр Энэтхэг Улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд Монгол Улсын БСШУЯ, БНЭУ-ын Шинжлэх ухаан, технологийн яам хооронд байгуулсан Протоколоор биотехнологийн салбарт хамтран ажиллах, судалгаа шинжилгээ хийх, харилцан мэргэжилтэн солилцох зэрэг асуудлыг тохиролцсон байна.

Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Ховд, Өмнөговь, Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дундговь, Дархан-Уул, Орхон аймаг, Улаанбаатар хотыг холбосон зайны сургалтын сүлжээ байгуулсан ба энэхүү нэгдсэн сүлжээ бий болсон нь багш нарын мэргэжил дээшлүүлэх, давтан бэлтгэх ажлын хүртээмж, чанар, үр ашиг, хурдыг нэмэгдүүлэх, боловсролын мэдээллийн үйлчилгээн дэх хот, хөдөөгийн ялгааг арилгахад томоохон алхам болж байгаа юм.

Шинэчлэн батлагдсан латин үсгийн стандартыг их, дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээний байгууллагуудад хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.

“Бага, дунд боловсролын шинэчилсэн стандартыг хэрэгжүүлэх, ерөнхий боловсролын сургуулийг 11 жилийн тогтолцоонд шилжүүлэхэд хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах төсөв/2004-2005/-ийг боловсруулж, баталгаажуулан гаргав.

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд гарч байгаа гэмт хэрэг, согтуурал, мансуурал, бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн “Хүүхэд-аюулгүй орчин” сэдэвт аяныг зохион байгуулах удирдамжийг батлан хэрэгжүүлж байна.

“Бүх нийтийн боловсролын долоо хоног”-ийн арга хэмжээний хүрээнд Бүх нийтийн боловсролын форумын хурлыг зохион байгуулав. Уг арга хэмжээнд Бүх нийтийн боловсролын форумын гишүүн гадаад, дотоодын байгууллагууд, аймаг, нийслэлийн Боловсролын газрын албан бус боловсролын арга зүйчид оролцов.

“Хүүхэд аюулгүй орчин” хоёр сарын аяны нээлтийг зохион байгуулж, энэ хүрээнд ЕБС-ийн сурагчдаас үйлдэж буй гэмт хэргийг бууруулахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж байна.

“Хүүхдэд ээлтэй сургуулийн бодлогын баримт бичиг”-ийг батлав.

“Төрийн захиргааны шинэчлэл хөтөлбөр”-ийн хүрээнд 12 аймаг, Улаанбаатар хотод байгуулагдсан алсын зайн сургалтын сүлжээг ашиглан ЕБС-ийн багш нарт зориулсан сургалтыг “Химийн боловсрол”-ын чиглэлээр аймгуудын ЕБС-ийн 320 багшийг хамруулан зохион байгуулав.

“Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх бодлого”-ыг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү баримт бичгийн зорилго нь багш, суралцагчид, эцэг эх, олон нийтийн бие биенээ ойлгож хүндэтгэсэн таатай харилцаанд суурилсан, хүүхэд бүрийн нөхцөл байдлаас үүдэн хүүхдийг ялгаварлах аливаа хандлагыг хязгаарласан, сургалтын ардчилсан, оролцоонд суурилсан,

идэвхтэй, хүүхэд төвт сургалтын арга зүйд тулгуурласан, аюулгүй, хэвийн материаллаг орчин бүхий хүүхдэд ээлтэй сургалтын орчин, үйл ажиллагааг бий болгоход оршиж байна.

Зайны сургалтын сүлжээгээр бага ангийн математикийн багш нарт зориулсан 3 өдрийн 24 цагийн модулийн сургалтыг зохион байгууллаа. Энд сургалтанд сүлжээнд холбогдсон нийт 12 аймгийн 340 багш хамрагдаж мэргэжлээ дээшлүүллээ. Уг сүлжээнд Ховд, Баян-Өлгий, Өвөрхангай гэсэн 3 аймаг, БСШУЯ-ыг нэмж холбох санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэв.

Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын талаар

“Шинжлэх ухаан-үйлдвэрлэл 2002-2003” үзэсгэлэнг зохион байгуулж, 30 гаруй эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн 200 орчим бүтээлийг тавьж нийтэд сурталчиллаа.

Төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөн ажиллуулж байна.

Дээд боловсролын сургалтын 5 байгууллагыг магадлан итгэмжлэх арга хэмжээ авснаар магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо 63-д хүрэв.

Сургалтын төрийн сангийн зээлээр 1993-2003 онд их, дээд сургууль, коллежид суралцан төгсөгчдийн сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлөх, оршин суугаа газраасаа 500 км ба түүнээс хол сургуульд суралцагч оюутныг өвлийн амралтаар орон нутагтаа зорчиход нэг талын унааны зардлыг төрөөс олгож байх асуудлыг шийдвэрлэв.

“Монгол Улсын ШУТ-ийн бодлогын чиг хандлага” сэдэвт үндэсний семинарыг зохион байгууллаа. Энэхүү семинараар ЮНЕСКО-гийн шинжээчдийн багаас ирүүлсэн Монгол Улсын ШУТ-ийг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний урьдчилсан судалгааны тайланг хэлэлцүүлж зөвлөмж гаргасан нь ач холбогдолтой боллоо.

Монголын залуу эрдэмтэн судлаачдын II чуулганыг зохион байгуулав.

Эрдэм шинжилгээний нэгдсэн номын сан байгуулж, түүнийг компьютержүүлэн тоноглох арга хэмжээ авч ашиглалтад оруулахад бэлэн болгов.

Соёл, урлагийн талаар

Морин хуур хөгжмийг “Хүн төрөлхтөний утга соёл, аман өвийн шилдэг дээжис”-т бүртгэсэн тухай ЮНЕСКО-гийн хүндэт батламжийг хүлээн авах ёслолын арга хэмжээг зохион байгуулав.

Монголын авъяаслаг хүүхдийн шүлэг, яруу найргийг эмхтгэн “Айсуй цагийн аяс” ном хэвлүүлэн, Хүүхдийн номын ордонд номын баяр зохион байгуулав.

“Угийн бичиг хөтлөх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах, айл өрхөд хөтлүүлэх угийн бичгийн стандартыг тогтоох санал боловсруулж, шийдвэрлүүлэх зорилгоор “Угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохицуулах зөвлөл байгуулах тухай” БСШУ-ны сайдын тушаал гарган нийт аймаг, дүүрэгт хүргүүллээ.

БСШУЯ, баруун бүс нутгийн хөгжлийг дэмжих холбоотой хамтран Баруун бүсийн урлагийн анхдугаар их наадмыг Нийслэл хотноо зохион байгуулав. Энэ арга хэмжээнд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгийн 130 гаруй уран бүтээлч, соёлын ажилтан оролцож, урлагийн тоглолт, Уран зургийн үзэсгэлэн, музейн шилдэг үзмэрийн үзэсгэлэн гаргаж сурталчлав. Баруун бүс нутгийн хөгжлийг дэмжих холбооноос баруун бүсийн 4 театр, чуулгад тус бүр 8,3 сая төгрөгийн үнэ бүхий соёлын үйлчилгээний автомашин олгов.

“Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг эцэслэн боловсруулж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

БНХАУ-ын соёлын өдрүүдийг зохион байгуулж, энэ үеэр хөгжмийн зэмсэг, фото зургийн үзэсгэлэн гаргаж, урлагийн болон циркийн тоглолт зэрэг арга хэмжээ явууллаа.

“Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарын хамтын ажиллагааны тухай хамтарсан комиссын хуралдааны Протокол”-ын төсөл болон “Монгол Улсын Засгийн газар, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар хооронд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт 2004-2006 онд хамтран ажиллах Хөтөлбөр” байгуулах асуудлыг шийдвэрлэв.

“Бичиг соёлын хишиг өдөр”-ийн хүрээнд “Бичиг үсгийн дурсгал” үзэсгэлэн, монгол бичгийн уран бичлэгийн уралдаан, асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулсны гадна 50 гаруй нэр төрлийн 20,0 сая төгрөгийн өртөг бүхий “2003 оны шилдэг ном, хэвлэл” болон Азийн сангаас олгож байгаа хүүхдэд зориулсан номыг аймаг, нийслэлийн номын сангуудад хүргүүлэв.

“Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хоорондын соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарт хамтран ажиллах тухай Хөтөлбөр”, “Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хооронд боловсролын үнэмлэх, диплом, эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Протокол” байгуулах талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

Чингис хааны мэндэлсний 840, Монголын тулгар төр байгуулагдсаны 800-н жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд “Их гүрнүүдийн цогцолбор” хөшөө дурсгалын нээлтийн ажиллагааг Хар хорин хотод зохион байгууллаа.

ЭРҮҮЛ МЭНД

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар авсан арга хэмжээ

2004 оныг эрүүл мэндийн салбарын хэмжээнд “Гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих жил” болгохоор шийдвэрлэсэн.

Хувийн эмнэлгийн хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хэмжээ, эрүүл мэндийн даатгалын сангаас хувийн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн даатгуулагчийн эмчлүүлсэн тусламж үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх журам, нийгмийн даатгалын байгууллага, ортой хувийн эмнэлгийн хооронд байгуулах гэрээг тус тус баталж, мөрдүүлж байна.

Биеийн тамир спортын үндэсний төвийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Биеийн тамир спортын улсын хороо” болгон зохион байгуулж, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, дүрмийг батлан ажиллаж байна.

Алсын түргэн тусламжийг зохицуулах журам, алсын дуудлага дуудах өвчний жагсаалтыг тус тус батлан мөрдүүлэв.

Шинээр бүтээгдсэн эмийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “Монгол Улсад шинээр бүтээгдсэн эмийг баталгаажуулах журам”-ыг батлан мөрдүүлсэн байна.

Залуусын болон нийт хүн амын дунд бэлгэвчийн хэрэглээг нэмэгдүүлэх дэд төслийн шугамаар нийлүүлж байгаа 7,1 сая төгрөгийн үнэ бүхий бэлгэвчийг Архангай, Сэлэнгэ, Дорнод, Өвөрхангай, Орхон аймаг болон Улаанбаатар хотод, “Эрүүл мэндийн интернешнл” ХХК-ны шугамаар Эрүүл мэндийн яаманд ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх зорилгоор хандивласан 4,9 сая төгрөгийн үнэ бүхий ариун цэврийн бүтээгдэхүүнийг ХӨСҮТ-д хуваарилан олгов.

Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, чанар, үр ашгийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийг 2004 онд төгссөн 151 мэргэжилтнийг аймаг, орон нутаг болон нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад томилж, төгсөгчдийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, сургалтын төлбөрийг барагдуулахад хяналт тавьж ажиллахыг аймгуудын эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгов.

НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлж байгаа “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” дэд хөтөлбөрийн шугамаар аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад 38,3 сая төгрөгийн үнэ бүхий зайлшгүй шаардлагатай эмийн хуваарийг батлан олгож байна.

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор “Тамхигүй орчин”, “Тамхи татаагүйд баярлалаа” ухуулга сурталчилгааны наалтын үнэ хуваарийг баталж, эдгээр материалыг ашиглаж хүн амын ялангуяа өсвөр үе, оюутан залуучууд олноор цугладаг олон нийтийн газар, бусад салбарын холбогдох байгууллагуудад хүргүүлж сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулж байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээ

ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсээс ирүүлсэн “Амьсгалын цочмог халтай хамшинж өвчний үед халдвараас хамгаалах болон шинжлэгдэхүүн цуглуулах 33 нэрийн эмнэлгийн хэрэгслэлийг Халдварт өвчнийг судлах үндэсний төв, Дорноговь аймаг болон Яамны нөөцөд хуваарилсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн даргаас Шувууны томуу өвчнөөс сэргийлэх талаар өгсөн үүргийн дагуу Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллав.

Дархлаажуулалт бүхий халдварт өвчинтэй тэмцэх, сэргийдэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын тушаалаар Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Сум багийн хүүхдүүдийг дархлаажуулалтанд бүрэн хамруулъя” уриан дор зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон 7729 хүүхдийг нөхөн дархлаажуулав.

Улаанбаатар хотод гарсан хоолны хордлогын дэгдэлтийн голомтод халдвар эсэргүүцэх арга хэмжээг зохион байгуулж 220 хүнд халдвар судлалын тандалт хийж, 179 хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх ажлыг зохион байгуулав.

2004 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар Монголэмимпекс компанийн агуулахад 253 нэрийн 1320,5 сая төгрөгийн, орон нутгийн эм хангамжийн компаниудад 98-184 нэрийн 589,5 сая төгрөгийн Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн үлдэгдэлтэй байна. Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн хангамж Улаанбаатар хотод 89,0 хувь, орон нутагт 87,0 хувьтай байна.

2004 оны эхний 5 сарын байдлаар 18296 эх амаржиж, 18249 амьд хүүхэд төрсөн байна. Энэ хугацаанд 17 эх эндсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3 тохиолдлоор, сүүлийн 5 жилийн дунджаас 7 тохиолдлоор буурсан байна. 0-1 хүртэлх насны 449 хүүхэд эндсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 4-өөр нэмэгдэж, сүүлийн 5 жилийн дунджаас 138 тохиолдлоор буурсан байна. 1-5 хүртэлх насны 114 хүүхэд эндэж өнгөрсөн оны мөн үеийнхээс 36 тохиолдлоор, сүүлийн 5 жилийн дунджаас 66-аар буурсан байна. 2004 оны 5 дугаар сард халдварт өвчний 11960 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн мөн үеийнхээс 385 тохиолдол буюу 3,1 хувиар буурч, 10000 хүн амд халдварт өвчний 48,0 тохиолдол ногдох боллоо.

3.БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Монгол Улсын Засгийн газраас 2004 оныг Усны шинэтгэлийн жил болгон зарласантай холбогдуулан “Усны шинэтгэл-XXI” үйл ажиллагааны хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Ойн хортон шавьж болон өвчинтэй тэмцэх дэд хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталж, хэрэгжүүлж байна.

Монгол орны халиу бугын тархац, нөөцийн үнэлгээ хийх хээрийн судалгааны ажлыг Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэн болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хийж байна.

Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар батлуулав.

“Гамшгаас хамгаалах улсын албадын удирдлагын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэл”-ийн дагуу “Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх улсын алба”-ыг байгууллаа.

Засгийн газрын тогтоолын дагуу Говийн бага дархан цаазат газрын “Б” хэсэгт хууль бусаар алт олборлосон үйл ажиллагаанд дүгнэлт хийж, улсын тусгай хамгаалалттай газар нутагт дахин зөрчил гаргуулахгүй байх талаар урьдчилан сэргийлэх, зөрчил илэрсэн тохиолдолд цаг алдалгүй таслан зогсоох, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор шуурхай ажлын штаб байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн ногоон бүсэд Ойн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих ажлаар Улсын мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газартай хамтарч Шарга морьт, Бэлх, Сэлх, Сэлбэ, яргайт, Хандгайт, Улиастай, Санзай аманд ой ашиглалтын байдалд шалгалт хийж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч байна.

Улаанбаатарт “Хот суурин газрын болзошгүй газар хөдлөлтийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт семинар зохион

байгуулав. Уг семинарт Азийн гамшгаас хамгаалах төв, Монгол Улсын гамшгаас хамгаалах ерөнхий газар болон аймаг, нийслэлийн удирдлагууд оролцов.

Агаарын бохирдлыг бууруулах талаар зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн бохирдол ялгаруулж байгаа техник хэрэгсэл, эх үүсвэрт төлбөр ногдуулах заалтыг “Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төсөл”-д тусгах концепцыг боловсрууллаа.

Дархан цаазат Богдхан уулын экосистемийн хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежмент, төлөв байдлын үнэлгээ” төсөл, түүний санхүүжилтээр Халиун буга сэргээн нутагшуулах ажлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, Хустайн байгалийн цогцолборт газраас буга, согоо тус бүр нэгийг барьж нутагшуулах ажлыг зохион байгуулав.

БОЯ, НүБ-ын Ази Номхон далайн эдийн засгийн комисс, АХБ-тай хамтран “Зүүн хойд Азийг шороон болон шар шуурганы аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх олон улсын анхдугаар семинар”-ыг Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

4. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Гаалийн тарифын хувь хэмжээг өөрчлөн тогтоох тухай тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанд оруулан хэлэлцүүлж, гурил, үр, хүнсний буудайн гаалийн татварыг 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдөр тэглэхээр шийдвэрлүүлсэн.

“Тариалангийн тухай” хууль, “Усны тухай” хуулийн шинэчилсэн найруулга, “Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиудыг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав.

АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “ХАА-н салбарыг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд баруун дөрвөн аймагт 2004 онд засварлах худгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг, Хүнс, хөдөө аж ахуйн яам хоорондын “Малын гаралтай бүтээгдэхүүний лабораторийг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлэх тухай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

2004 оны хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд тариаланчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулав.

“Хөдөө аж ахуйн техник, технологи-2004” олон улсын үзэсгэлэн худалдааг Улаанбаатар хотноо зохион байгуулж, уг арга хэмжээнд нийт 500 хүн оролцсон байна.

ХХААЯ, ҮХЯ, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг хамтран “Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт”-ыг зохион байгуулав.

НХХЯ, АХБ-ны Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр, Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг тодорхойлох нь зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа.

КР-1 төслийн хүрээнд ирсэн 19,0 тонн улаан буудай хүлээн авах ёслолын ажиллагааг зохион байгуулж, улаан буудайг борлуулах үнийг тогтоох, хөрөнгө төвлөрүүлэх тухай шийдвэр гаргаж, улаан буудайг аймаг орон нутаг, аж ахуйн нэгжийн захиалгын дагуу олгох ажлыг зохион байгуулж байна.

“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлж байгаа “Хөдөө аж ахуйн хөгжлийн хөтөлбөр” төслийн 2003 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг хөтөлбөрийн үндэсний зөвлөл, төслийн удирдах зөвлөлийн хуралдаанд тус тус хэлэлцүүлэв.

2004 оноос шинээр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн таван төслийн талаар холбогдох хүрээлэнгүүдтэй гурван талт гэрээг баталгаажуулав.

Улсын нөөц, Буудайн сантай хамтарч тариалан бүхий 300 гаруй аж ахуйн нэгжид 16,0 мянган тн үрийг гэрээгээр олгов.

КР-2 төслийн хуримтлалын сангийн хөрөнгөөр техник шинэчлэх санал, мөн уг төслийг хүсэлтийн дагуу үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай танилцуулгыг Японы талд хүргүүлж, тэндэрээр нийлүүлэгдсэн 50 ш морин хадуурыг хүлээн авах, Кубота М-100 тракторын зарим сэлбэгийг нийлүүлэх гэрээ хийх ажлыг зохион байгуулав.

Газар тариалангийн 153 аж ахуйн нэгжтэй 4,2 тэрбум төгрөгийн өр авлагын тооцоо нийлж, 30,0 гаруй сая төгрөгийн өр авлагыг барагдуулах арга хэмжээ авав.

Услалтын системийг сэргээн засварлах тендерт шалгарсан Блуган аймгийн Шувуутын гол, Хөвсгөл аймгийн Хавчуу, Говь-Алтай аймгийн Гуулийнгийн тал, Улаанбаатар хотын Аюушийн ам, Сэлэнгэ аймгийн Хонгор-Овоо зэрэг услалтын системийг өмчлөгч, эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж, засварыг эхлүүлэх арга хэмжээ авлаа.

Дундговь, Өмнөговь, Дорнод, Сэлэнгэ, Дорноговь, Баянхонгор, Сүхбаатар, Төв, Өвөрхангай аймгуудын худгийн засвар болон шинээр худаг гаргах гүйцэтгэгчээр сонгогдсон аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

“Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, техник технологи-2004” олон улсын хаврын үзэсгэлэнг зохион байгуулав.

ДЭД БҮТЭЦ

Стратегийн удирдлагын талаар

Цахилгаан түгээх сүлжээнүүдэд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилго бүхий журам боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

“Эрчим хүчний хөтөлбөр-1” төсөлд Германы Засгийн газраас авах нэмэлт зээлийн гэрээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

Авто тээврийн салбарт хамтран ажиллах тухай, “Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улс-БНКиргиз Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгууллаа.

Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Авто зам хөгжүүлэх II төсөл”-ийн хүрээнд Налайх-Чойр чиглэлийн 200 км хатуу хучилттай авто зам барих БНХАУ-ын “China Tiesiju Civil Engineering Group” компанийн мэргэжлийн 1100 ажилтныг улсын хилээр оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

Автомашин шатахуун зарцуулалтын жишиг норм, эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм, резин дугуйн болон зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарын жишиг нормыг тус тус батлан мөрдүүлж байна.

“Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Засгийн газрын хуралдаанаар батлав. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Хөвсгөл аймагт “Мөсний баяр” арга хэмжээг зохион байгуулав.

Хийн түлш болон хийн тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвараас, хийн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлөх тухай хуулийг батлуулав.

Мэдээлэл холбоо, шуудангийн салбарт хувийн хөрөнгө оруулалт оруулах журмыг батлан мөрдүүлж байна.

Бодлогын зорилтыг зохицуулах талаар

Баруун-Урт, Сүхбаатарын 10 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө, Баян-Өлгийн аймгийн нисэх буудлын барилгын ажлыг дуусгаж, ашиглалтанд хүлээн авлаа.

ШУТИС-ийн Холбоо, мэдээллийн технологийн сургууль дээр байгуулсан Алсын зайн сургалтын сүлжээний төв болон Орхон, Дархан-уул, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Архангай зэрэг зургаан аймгийн Боловсрол, соёлын газрыг холбосон алсын зайн сургалтын сүлжээний эхний шатыг ашиглалтад оруулав.

Хийн түлш болон хийн тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвараас, хийн салбарт үйл ажиллагаагаа эрхлэгч аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төслийг УИХ-д өргөн барив.

Авто тээврийн салбар, Замын салбар, Түлш, эрчим хүчний салбар болон Төмөр замаар үйлчлүүлэгч байгууллага, төмөр замын өртөөний болон Нийтийн аж ахуйн үйлчилгээний, Барилгын байгууллагын болон шуудангийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг тус тус

зохион байгуулж, салбарын хэмжээнд баримталж байгаа бодлого, цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцэн, тулгамдаж байгаа асуудлыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргасан байна.

Ази, Номхон далайн орнуудын цахилгаан холбооны байгууллага, Дэлхийн худалдааны байгууллага, Дэд бүтцийн яам хамтран “Зүүн Азийн орнуудын цахилгаан холбоо ба худалдаа” сэдэвт олон улсын уулзалт семинарыг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

Дэд бүтцийн яам, Мэдээллийн технологийн үндэсний парк, МИДАС ТББ хамтран “Монгол программ хангамж-2004” үзэсгэлэн-худалдааг Улаанбаатар хотноо зохион байгуулж, мэдээлэл холбоо, программ хангамжийн 20 гаруй байгууллага, компанийг оролцуулав.

Тээврийн хэрэгслийн улсын үзлэг тооллогын ажил төлөвлөсөн хугацаандаа явагдаж дууссан ба замын санд 2,2 тэрбум төгрөгийг төвлөрүүлэв. Энэ жилийн хувьд автотээврийн тухай болон Автотээврийн хэрэгслийн албан татварын тухай хуулиудын нэмэлт өөрчлөлт орсны дагуу оношлогоо, тооллогын ажлыг тусад нь зохион байгуулж байгаа ба оношлогоог 3-11 дүгээр сарын хооронд явуулж байгаагаараа онцлог юм.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Чойр-Сайншанд-Замын-Үүдийн чиглэлийн авто замыгбарих “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл”-д гарын үсэг зурав.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газраас “Монголд зочлох жил” болгон зарласан тогтоолыг үндэслэн нийслэлийн Засгийн даргын Тамгын газрын шийдвэрийн дагуу жуулчны мэдээллийн төвийн байр болох Урт цагааны 2 дугаар корпусын 2 давхарын байрны засварын ажлыг эхлүүлээд байна. Аялал жуулчлалын газар, Монгол аялал жуулчлалын холбоо, нийслэлийн Захирагчийн ажлын албаны Аялал жуулчлалын хэлтэс, Монголын урлагийн ажилтны зөвлөл хооронд “Жуулчны мэдээллийн төв” байгуулах тухай хамтран ажиллах санамж бичиг байгуулав.

Дөргөний усан цахилгаан станц барих, Арвайхээр, Баянхонгорын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөний барилга, 11 сумын төвийг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөг барьж холбох барилга угсралтын ажлыг тус тус эхлүүлэв.

БНХАУ-ын Засгийн газрын 50 сая юанийн буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэгдсэн 20620 нарны цахилгаан үүсгүүрийг хүлээн авах ажлыг зохион байгуулж, үнэ тогтоон аймгуудаас ирүүлсэн захиалгын дагуу 11000 гаруйг хуваарилан олгоод байна.

Монгол-Солонгосын эрчим хүч, эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссын хуралдааныг зохион байгуулав.

Discover Mongolia жилийн арга хэмжээний төлөвлөгөөнд орсон Олон улсын Найрамдал марафон гүйлтийн тэмцээн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт боллоо. Тэмцээнийг “Жуулчин” ХК, Аялал жуулчлалын газар хамтран 2 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд БНСУ, Япон, АНУ, ОХУ, Энэтхэг, Филиппин, БНХАУ, Герман, Монголын тамирчид, сонирхогчид оролцлоо.

Туурайн төвөргөөн Олон улсын шинэ хөгжмийн наадам манай улсад 1999 оноос хойш жил бүр зохиогдож байгаа бөгөөд энэ жилийн наадам Улаанбаатар, Элсэн тасархай, Хархоринд болж АНУ, ХБНГУ, Франц, Швейцар, Австри, Голланд зэрэг 14 орны 80 гаруй уран бүтээлчид, 500 гаруй сонирхогчид оролцов.

Баянхонгор, Зуунмод хотын цэвэр цсны шугам, усан сангийн барилга, байгууламж болон Ховдын цементийн үйлдвэрийг тус тус ашиглалтад орууллаа.

Дэд бүтцийн яам, Шуудан цахилгаан холбооны газар, Олон улсын сансарын холбооны байгууллага-Интелсаттай хамтран сансарын холбооны хөгжлийн өнөөгийн ололт, цаашдын зорилтын талаарх семинарыг зохион байгуулав.

5. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАДААД БОДЛОГО

БАТЛАН ХАМГААЛАХ

Стратегийн удирдлага, төлөвлөлтийн талаар

“Иракт үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багийг солих тухай” асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

Монгол Улсад АНУ-ын штабын дарга нарын нэгдсэн хорооны дарга генерал Майерс айлчилж, хоёр улсын цэргийн хамтын ажиллагааны талаар ЗХЖШ-ын даргатай ярилцаж, Зэвсэгт хүчний 150 дугаар ангид зочлов.

Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд цэрэг-техникийн салбарт байгуулах хэлэлцээрийн тухай, Хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчдын тоо, цэрэг халалт, таталтын хугацаа тогтоох тухай, Цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай, Дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулах төлбөрийн суурь хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлуудыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, тогтоол гарган хэрэгжүүлж байна.

"Цэргийн зориулалтаар ашиглаж байсан газар орныг сэргээх, дахин ашиглах нь" сэдэвт олон улсын бага хурлыг НАТО-тай хамтран амжилттай зохион байгуулан явууллаа. Энэхүү хурал нь Монгол Улсад цэргийн зориулалтаар ашиглаж байсан газар орны талаар мэдээллийн санг бүрдүүлэх, тэдгээрийг нөхөн сэргээх, дахин ашиглахад гадаад орнууд, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах урьдчилсан боломж бүрдүүлсэн ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан "Аймаг нийслэл дүүргийн цэргийн штабуудын ажилтныг сэлгэн ажиллуулах журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинээр томилогдсон Аймаг, дүүргийн Цэргийн штабын дарга нарын ажлыг хүлээлцүүлэх /Орхон, Дорноговь, Хөвсгөл аймаг, Чингэлтэй дүүрэг/ арга хэмжээг зохион байгуулав.

Батлан хамгаалах салбарын гадаад арга хэмжээний төлөвлөгөөний дагуу манай оронд зохион байгуулагдах Монгол Улс, АНУ-ын хамтарсан "Хааны эрэлд-2004" дадлага сургууль, Их Британий Батлан хамгаалахын атташегийн ажлын айлчлал, Олон үндэстний салаадын хээрийн сургуульд салаа оролцуулах зэрэг гадаад арга хэмжээний бэлтгэл ажил хийгдээд байна.

Салбарын хэмжээнд актлах, буулгах, худалдах зарим барилга байгууламжийн чанар байдал, цэргийн зэвсэглэл, пуужин, галт хэрэглэлийн ашиглалт, хадгалалт, зарцуулалт, техникийн чанар байдал мөн зарим ангиудад байгаа актлах зэвсэглэл, техникийн байдалд түүвэрчилсэн үзлэг явууллаа.

Зэвсэгт хүчний сургалт бэлтгэл, бэлэн байдлын талаар

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор Зэвсэгт хүчний удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулав.

Тайван цагт Зэвсэгт хүчинд алба хаах бие бүрэлдэхүүний тооны дээд хязгаарыг тогтоох санал, "Байгалийн гамшиг, ослын үед Улсын онцгой комиссын шийдвэрээр цэргийн анги, салбаруудыг ажиллуулах журам", Улсын нөөцөд байршуулах материал, хэрэгслийн тоо хэмжээний саналыг боловсруулж, Зэвсэгт хүчний дайчилгааны хэрэгцээт материал, хэрэгслийн тооцоо, цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн дайчилгааны бэлтгэл нөөцийн байршлын мэдээг нэгтгэн гаргалаа.

Цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу гэрээт цэргийн нэг, хоёр жилийн цэргийн албан хаагчидтай мэргэжлийн бэлтгэл, байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх жигдрэлтийг хангах сургалт, хугацаат цэргийн албан хаагчидтай мэргэжлийн бэлтгэл, салбарын жигдрэлтийг хангах сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллав.

Хятадын ардын чөлөөлөх армийн Жанжин штабын орлогч дарга, хурандаа генерал Сюн Гуанкай тэргүүтэй төлөөлөгчид, ХБНГУ-ын Энхийг сахиулах хүчний сургалтын төвийн захирал генерал Бергер тэргүүтэй төлөөлөгчид, АНУ-ын Номхон далай дахь Агаарын цэргийн хүчний төлөөлөгчид тус тус манай оронд айлчлан, Батлан хамгаалах яамны төлөөлөгчид БНХАУ-д ажлын айлчлал хийсэн нь Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

Зэвсэгт хүчний холбоочдын тусгай тактикийн хээрийн сургуульд бүх ангиудын холбоочид, тусгай холбоочид оролцож, радиостанцаа дэлгэх, тохируулах, холбоо тогтоох, бодит болон сургуулийн мэдээлэл солилцох, дадлага сургууль хийж, ур чадвараа дээшлүүлэв.

Энхийг сахиулах ажиллагааны Зүүн Азийн орнуудын салааны дадлага-сургуулилалтын төлөвлөлтийн эцсийн шатны бага хурал зохион байгуулах, Ж.Маршалын нэрэмжит аюулгүй

байдлын судалгааны төвийн дээд албан тушаалтны семинар, АНДБН-ийн аюулгүй байдлын судалгааны гүйцэтгэх ажилтны дамжаанд суралцуулах, Дэлхий дахины нисэх хүчний дарга нарын бага хуралд төлөөлөгч оролцуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүллээ.

АНУ-ын Тэнгисийн явган цэргийн багтай хамтран явуулах Энхийг сахиулах ажиллагааны “Хааны эрэлд-2004” хээрийн сургуулийн ажиллагааг Таван толгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд эхлүүлж, ЗХЖШ-аас “Иракийн эрх чөлөө” ажиллагаанд оролцож буй цэргийн багтай шуурхай холбоог хангах зорилгоор АНУ-ын талаас нийлүүлж буй богино долгионы радио станцын тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулан, радиохолбоочдын сургалтыг зохион байгуулав.

“Кобра Гоүлд олон үндэстний хээрийн сургууль”-д Монголын зэвсэгт хүчний төлөөлөгчдийг оролцуулах тухай МУ-ын Засгийн газар, Тайландын Вант Улсын Засгийн газар хоорондын харилцан ойлголцох санамж бичиг, Зэвсэгт хүчний офицер, ахлагч, цэргийн албан хаагчдад ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай асуудлыг шийдвэрлэв.

Монгол Улс, АНУ-ын Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны 2004 оны төлөвлөгөөний дагуу хоёр талын дунд хэмжээний уулзалт, АНУ-ын Тэнгисийн явган цэргийн багтай хамтарсан Энхийг сахиулах ажиллагааны “Хааны эрэлд-2004” хээрийн сургуулийг Таван толгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд зохион байгууллаа.

Монголын Бүх ард түмний 11 дүгээр спартакиад, Бүх цэргийн наадмын хүрээнд зохион байгуулж байгаа Зэвсэгт хүчний спорт-урлагийн тоглолтыг Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулж, Зэвсэгт хүчний анги, салбаруудын цэргийн ёслолын жагсаал, гардан байлдаан, зэвсэгтэй, зэвсэггүй жагсаалын ажиллагаа, бөмбөрчдийн үзүүлэх болон урлагын тоглолтуудыг нийслэлчүүдэд сонирхуулсан нь Зэвсэгт хүчний шинэчлэлийн явц, үр дүнг илтгэн харуулсан чухал арга хэмжээ болов.

Улаанбаатар цэргийн хүрээний ангиудад цэргийн албанд татагдан ирсэн шинэ дайчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, өвчний учир цэргийн албанд тэнцэхгүй 7 хүнийг цэргийн тангараг өргөхөөс нь өмнө орон нутагт нь буцаан, “Иракийн эрх чөлөө” ажиллагаанд оролцох 3 дугаар ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүнд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийлгэж, дүгнэлт гарган Шри Ланка улсад явагдах Энхийг сахиулах ажиллагааны хамтарсан сургуульд оролцох салааны бүрэлдэхүүнийг хүн нэг бүрийн эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалаар хангалаа.

ГАДААД ХАРИЛЦАА

Стратегийн удирдлагын талаар

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Арабын БН Египет Улс, БН Турк Улсад албан ёсны айлчлал хийв. Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр Египеттэй Хөрөнгө оруулалт, Эдийн засаг, техникийн салбарт хамтран ажиллах тухай, Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд болон Соёлын Хөтөлбөр, БНТУ-тай ТИКА-ийн Төлөөлөгчийн газрыг Улаанбаатарт нээх тухай болон хоёр улсын ХХААЯ хооронд хамтран ажиллах тухай хэлэлцээрт тус тус гарын үсэг зурав.

Монгол Улсын Их Хурлын дарга С.Төмөр-Очир тэргүүтэй төлөөлөгчид БНКазахстан Улс, БНКиригиз Улсад айлчлав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр БНЭУ-д албан ёсны айлчлал хийлээ. Энэ үеэр Монгол Улс, БНЭУ-ын Хамтарсан мэдэгдэл гаргав. Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газрын хооронд “Мал эмнэлэг болон сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт хамтран ажиллах тухай”, “Сансар судлалын шинжлэх ухаан, технологи ба хэрэглээний салбарт хамтран ажиллах тухай” зэрэг хэлэлцээр байгуулсан.

Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулууны урилгаар ОХУ-ын Гадаад хэргийн сайд И.С.Иванов Монгол Улсад айлчлав. И.С.Иванов Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунтай хэлэлцээ хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхий сайд Н.Энхбаяр нарт тус тус бараалхав.

Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун БНХАУ-д албан ёсны айлчлал хийж, энэ үеэр Бээжин хотноо хуралдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын Гадаад хэргийн сайд нарын уулзалтад зочны статустай оролцов.

Монгол, финландын хоорондын хамтарсан комиссын Хельсинки хотноо болсон есдүгээр хуралдаанд оролцсон хоёр талын төлөөлөгчид нийгэм, эдийн засгийн байдлын талаар харилцан мэдээлж, харилцан ашигтай салбарууд болох жижиг, дунд үйлдвэр, уул уурхай, төмөрлөгийн үйлдвэрлэл, ойн аж ахуй, ойжуулалт, байгаль хамгаалал, эрчим хүч, аялал жуулчлал, боловсрол, шинжлэх ухаан, технологи, хөдөө аж ахуй, тээвэр, тэр дундаа төмөр замын тээвэрлэлтийн чиглэлээр хамтран ажиллах боломжтой гэж тодорхойлов.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин БНБУ-д айлчилж, хоёр орны төрийн захиргаа болон боловсрол, соёл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал зэрэг асуудлаар харилцан санал солилцов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди “Их өрийн асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн тухай илгээлтийг ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинд хүргүүлэв. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр БНАСАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр ярилцаж тохиролцсоны дагуу Умард Солонгост төлөх шилжих рублийн өрийн асуудал бүрэн гүйцэд шийдвэрлэгдэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын урилгаар Шведийн Вант Улсын Ерөнхий сайд Горан Перссон Монгол Улсад албан ёсоор айлчлав. Айлчлалын үеэр албан ёсны хэлэлцээ хийснээс гадна ганцаарчилсан уулзалт хийв. Шведийн Засгийн газрын тэргүүний энэ удаагийн айлчлал нь хоёр талын харилцааг цаашид эрчимжүүлэх, ялангуяа Монгол Улсын Ерөнхий сайдын Шведэд 2003 онд хийсэн айлчлалын үеэр яригдсан асуудлуудыг урагшлуулахад ач холбогдолтой байсан бөгөөд Монголын экспортыг нэмэгдүүлэхэд Шведийн талтай хамтран ажиллах, Шведийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, батлан хамгаалах, болвсрол, соёл, техник, хөгжлийн хамтын ажиллагаа зэрэг бусад салбарт хамтран ажиллах тодорхой асуудлуудыг авч хэлэлцэв.

ӨМӨЗО-ны Ардын Засгийн газрын тэргүүлэх зөвлөх Жоу Дэхай тэргүүтэй Засгийн газар, бизнесийн төлөөлөгчид Монгол Улсад айлчлав.

Британийн Гадаад болон хамтын нөхөрлөлийн хэргийн яамны Парламентын харилцааны газрын дарга Матью Хамлин УИХ-ын Тамгын газрын шугамаар Монголд ажлын айлчлал хийж, холбогдох албаны хүмүүстэй уулзан манай УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаа, УИХ-аас Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон төрийн бусад байгууллагуудтай хэрхэн харилцдаг талаар санал солилцов.

БНСУ-ын Хөдөлмөрийн яам гадаадын ажилчдын тухай хууль ирэх 8 дугаар сараас хэрэгжихтэй холбогдуулан шинэ хуулийн дагуу гэрээгээр ажиллуулах тогтолцоогоор 25 мянга, жижиг, дунд үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэлийн дадлага хийлгэх тогтолцоогоор 38 мянган хүнийг хүлээн авна.

Энэ оны нэгдүгээр сарын 26-28-нд Улаанбаатарт Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн зөрчлийг шүүхээр шийдвэрлэх асуудлаар Зүүн Хойд Азийн дэд бүсийн семинарыг НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газартай хамтран зохион байгуулж, зөвлөмж батлан гаргав.

Мянганы сорилтын сангаас тусламж авах өргөдөл гаргах эрх бүхий 16 орны жагсаалтад Монгол Улсыг хамруулсан тухай АНУ-ын тал мэдэгдэв. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар МСС-ийн Үндэсний зөвлөлийг байгуулан ажиллуулж байна.

БНСУ-ын гадаадын ажилчдын тухай хууль ирэх 8 дугаар сараас хэрэгжих бөгөөд манай улс Солонгосын Засгийн газрын ажиллах хүч авах гадаад орнуудын жагсаалтад багтав. Үүнтэй холбогдуулан хоёр улсын Хөдөлмөрийн яамд хоорондын Протоколд НХХ-ийн дэд сайд С.Чинзориг гарын үсэг зурав. Солонгосын Засгийн газар хоёр орны хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны шугамаар манай улсаас 200 хүнийг ХАА-н салбарт нэмж авахаар шийдвэрлэв.

БНСВУ-ын Ерөнхий сайд Ван Кхай, мөн БНСВУ-ын Үндэсний Их хурлын Тамгын газрын дарга Буй Нгок Тхань тэргүүтэй төлөөлөгчид, БНХАУ-ын Эрүүл мэндийн дэд сайд тэргүүтэй төлөөлөгчид, БНЧУ-ын Үйлдвэр худалдааны яамны нэгдүгээр орлогч сайд В.Петжичек, Байгаль орчны дэд сайд Т.Новотны, ОХУ-ын Кемеров мужийн захирагч А.Г.Тулеев, БНХАУ-ын ГЯЯ-ны Азийн хэлтсийн орлогч дарга Кун Сюанью тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад тус тус албан ёсны айлчлал хийлээ.

Зүүн Азийн Эдийн засгийн чуулга уулзалтад Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Уулзалтын үеэр Л.Эрдэнэчулуун БНСУ-ын Гадаад хэрэг, худалдааны сайд Бан Ги Мүн, Японы Олон улсын хамтын ажиллагааны банкны Гүйцэтгэх захирал Т.Ивашита нартай тус тус уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын орнуудын төрийн тэргүүн нарын уулзалтад оролцов.

Манай улсын “Хөдөө орон нутаг дахь эрүүл мэндийн тогтвортой үйлчилгээг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд зориулж Япон Улсын Засгийн газар болон НҮБ-аас Хүний аюулгүй байдлын итгэмжит сангаар дамжуулан 658 мянган ам.долларын тусламж үзүүлэх шийдвэрийг гаргасан бөгөөд Хөтөлбөрийг НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлэхээр болоод байна.

Монгол Улсын Засгийн газраас НҮБХС-ийн дэмжлэгтэйгээр Хүүхдийн асуудлаарх үндэсний дээд хэмжээний чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Чуулга уулзалтад НҮБ-ын ЕНБД-ын даргын туслах, НҮБХС-ийн Гүйцэтгэх захирлын орлогч Кул Гуатам оролцсон ба тэрээр Монголд байх хугацаандаа манай төр, засгийн удирдлагуудтай уулзав. Түүний айлчлалын үр дүнд Нью Йорк хотноо болсон НҮБХС-ийн Гүйцэтгэх товчооны хуралд анх удаа монгол хүүхэд оролцов.

Японы Засгийн газраас үзүүлж буй буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх “Улаанбаатар хотын ундны усны барилга, байгууламжийг сайжруулах төсөл”, “2003 оны санхүүгийн жил Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэг” төслийн хоёрдугаар ээлж, “2004 оны санхүүгийн жил Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэг” төслийн тусламжийн ноотод тус тус гарын үсэг зурав.

Япон Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Ерөнхий боловсролын сургуулиудын барилга, байгууламжийг сайжруулах” 7,4 сая ам.долларын өртөг бүхий төслийн тусламжийн ноот бичигт гарын үсэг зурав.

6. ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО

Эрх зүйн шинэтгэл, хууль зүйн бодлогын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх стратеги зорилтын хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан ажлыг хийж гүйцэтгээд байна.

Яамны эрх зүйн байдлын тухай, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулан батлууллаа. Мөн Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн төсөл “Даатгалын хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах тухай” УИХ-ын тогтоолын төслийн хамт боловсруулж хаврын чуулганаар батлуулсан.

“Замын хөдөлгөөний дүрмийг шинэчлэн батлах тухай”, “Нийслэлийн захиргааны шүүхийн байрны тухай”, “Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”, “Шүүгчийн сургалтад хөрөнгө гаргах тухай”, “Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрэм батлах тухай”, “Марубений шүүх хурлын тухай”, “Дотоодын цэргийн хамгаалалтад байх улсын онц чухал объектын жагсаалт батлах тухай” зэрэг Засгийн газрын тогтоолын төслийг батлуулсан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүний санаачилсан Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний эрхийн комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Терроризмтэй тэмцэх тухай зэрэг 17 нийт хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд байна.

Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн 180 актыг хянаснаас 124 актыг улсын бүртгэлд бүртгэж, 15 актыг хуульд нийцүүлэхээр, 40 актыг хэм хэмжээ тогтоогоогүй үндэслэлээр буцаалаа.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл 108, Төрийн бус байгууллага 626, шашны байгууллага 26, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага 63-г улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгов. Мөн Төлбөрт

таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нийт 50 байгууллага, иргэнд олголоо.

“Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр”, “Төлбөрөөс зайлсхийгчдийг эрэн сурвалжлах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн хамтран ажиллах тухай журам”, “Банкны өр барагдуулах газрын нэхэмжлэлтэй шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн төлбөрийн тооцоог хийх, мэдээ, судалгаа гаргах тухай журам”, “Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн гэрчилгээний загвар, түүний тодорхойлолтыг шинэчлэн батлах тухай” (нууц), “Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, хууль зүйн хэлтсийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ажлаар нь дүгнэж, үнэлгээ өгөх журам”-ыг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлууллаа.

“Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгох, сургаж бэлтгэх, үүрэг гүйцэтгэх журам”, “Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалат, түүнд хяналт тавих журам” “Шүүх эмнэлгийн магадлагаа явуулах дүрэм, заавар” зэргийг батлууллаа.

Хуульчдаас сонгон шалгаруулах тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Хуульчдын анхны сонгон шалгаруулалтыг улсын хэмжээгээр бүсчлэн зохион байгууллаа. Тус сонгон шалгаруулалтад нийт 1717 хүн хамрагдсанаас 1023 хүн буюу нийт оролцогчдын 59% тэнцсэн үзүүлэлттэй байлаа. Одоогийн байдлаар сонгон шалгаруулалтад тэнцсэн хүмүүст хуульчийн гэрчилгээг олгох, хуульчийн нэгдсэн санд оруулах ажил хийгдэж байна.

Эрх зүйн сурталчилгааны ажлын хүрээнд хууль сурталчлах ажлыг “2004 онд олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах төлөвлөгөө”, “Ажил гүйцэтгэх гэрээ” /10 гаруй гэрээ/-ний дагуу гүйцэтгэж ирлээ. Үүнд:

1. “Хуулийн цаг” нэвтрүүлгийг “Арбитрын тухай”, “Газрын тухай”, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай”, “Иргэний хууль”, “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-иар нийтдээ 24, давтамжтайгаар 48 удаа зохион байгууллаа.

2. “Захиргааны шүүх” нэвтрүүлгийг “MN 25” телевиз, Цагдаагийн академи, “Шихихутуг” хууль зүйн дээд сургуультай хамтран 12, давтамжтайгаар 24 удаа бэлтгэж олон нийтэд сурталчиллаа. Хууль зүйн тайлбарт зохиомжит теле нэвтрүүлгийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, хууль зүйн үндэслэлийг мадаггүй байлгах үүднээс урьдчилан бичсэн нэвтрүүлгийн зохиомжийг өндөр мэргэжлийн хуульч, эрдэмтдээр хянуулж, тэднээс зөвлөлгөө авах зэрэг ажлыг тогтмол зохион байгуулав.

3. Сар бүр зохион байгуулсан хууль сурталчлах уралдаант “Цэц” нэвтрүүлгийг энэ оны эхний улирал дуустал үргэлжлүүлэв.

4. Радио нэвтрүүлгийн хувьд хууль сурталчлах “Шинэ товчоо” нэвтрүүлгийг Монгол Улсын эрүүгийн хуулиар бэлтгэн 6, давтамжтайгаар 12 удаа олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулав.

5. Хууль, хууль тогтоомжийг иргэдэд хүргэх арга хэлбэрийн нэг болох хууль, хууль тогтоомжийн эмхтгэл, гарын авлага бэлтгэх, хянах, хэвлүүлэх, түгээх ажлыг зохион байгууллаа.

Аймаг, нийслэл дүүргийн ЗДТГ-ын эрх зүйн сургалт-сурталчилгааны асуудал хариуцсан ажилтнуудын сургалт-семинарыг зохион байгууллаа.

Хууль зүй, дотоод хэргийн яам, агентлаг, хууль сахиулах байгууллагуудын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2004 оны эхний хагас жилд тус яам БНТУ, БНКаЗУ, АНУ, Япон, БНУкрУ-ын Хууль зүйн болон Дотоод хэргийн яамд, хууль сахиулах бусад байгууллагуудтай харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ажиллаа. Тухайлбал:

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, БНТУ-ын Хууль зүйн сайд Жамил Чечекийн урилгаар 2003 оны 12 дугаар сард тус улсад албан ёсны айлчлал хийлээ. Энэ айлчлалын үеэр сайд Ц.Нямдорж, БНТУ-ын Хууль зүйн сайд Жемил Чечек, Дотоод хэргийн сайд Абдулкадир Аксу нартай хэлэлцээ хийн 2000 онд байгуулсан Монгол Улсын Хууль зүйн яам, БНТУ-ын Хууль зүйн яам хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээрт үндэслэн Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, БНТУ-ын Хууль зүйн яам хооронд 2004-2005 онд хамтран ажиллах

Протокол, шинээр БНТУ-ын Дотоод хэргийн яамтай харилцан ойлголцлын санамж бичигт тус тус гарын үсэг зурлаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн дарга Ц.Нямдорж БНКазахстан Улсын нийслэл Астана хотноо болсон Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын комиссын III хуралдаанд Монголын талын төлөөлөгчдийг тэргүүлэн оролцлоо. Монгол Улсын ХЗДХЯ, БНКазахстан Улсын ижил төрлийн яамдтай хамтран ажиллах талаар хэлэлцээр байгуулахаар төслөө харилцан солилцоод байна.

Гадаадын зээл, буцалтгүй тусламж, төслийг өргөжүүлэх, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих зорилтын хүрээнд 2004 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яам, НҮБ-ын Хүн амын сангийн ДОХ-той тэмцэх Хөтөлбөрийн хооронд Цагдаа, хил хамгаалах, дотоодын цэргийн албан хаагч нарын дунд ДОХ-оос урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах хэлэлцээрт гарын үсэг зурлаа.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Шүүх, эрх зүйн шинэчлэлт төслийн хүрээнд Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт судалгааны үндэсний төвийн барилга 6 дугаар сарын 16-ны өдөр ашиглалтад орлоо. Хууль зүйн үндэсний төв үйл ажиллагаагаа эхэлсэнээр хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдыг давтан сургах, эрх зүйн сурталчилгааг үндэсний хэмжээнд явуулах боломж бүрдэж байна.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын ажилтны чадавхийг бэхжүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, менежментийг боловсронгуй болгоход дэмжлэг тусалцаа үзүүлэх асуудлаар Монголын Нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/-тэй хамтран хандивлагч улс, олон улсын байгууллагуудын зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Уулзалт Монголын цагдаагийн байгууллага, түүний үйл ажиллагаа, өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлагатай салбар чиглэлийг хандивлагчдад танилцуулсанаараа ихээхэн ач холбогдолтой болсон юм.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Дэлхийн банктай хамтран эрх зүйн салбарт хамтран ажиллаж байгаа доноруудын зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Дэлхийн банк, НҮБ, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Жайка, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын 12 байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчид оролцож өнгөрсөн хугацаанд хамтран ажилласан ажлын явц, үр дүнг дүгнэснээс гадна цаашид эрх зүйн шинэчлэлийн аль салбарт анхаарах, хэрхэн үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, үр нөлөөг сайжруулах талаар ярилцаж нэгдсэн ойлголтод хүрсэн болно.

Азийн хөгжлийн банк Чойр-Замын Үүдийн авто зам барих төслийн хүрээнд хүнийг хууль бусаар хил давуулах, ДОХ, бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 300 мянган ам.долларын санхүүжилт бүхий дэд төсөл хэрэгжүүлэхээр боллоо. Уг төсөл нь олон улсын чанартай авто зам баригдсантай холбоотойгоор хар тамхи, мансууруулах бодис, хүнийг хууль бусаар хил давуулах гэмт хэрэг үйлдэгдэх, ДОХ бусад халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм.

Дүрвэгсдийн эрх зүйн асуудлаар НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газартай 1956 оны Дүрвэгсдийн конвенци, түүний нэмэлт протоколд Монгол Улс нэгдэн орох асуудлаар хамтран ажиллаа. Энэ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Цэрэндорж тус байгууллагын Бээжин дэх бүсийн төлөөлөгч К.Митчелыг хүлээн авч уулзсанаас гадна Улаанбаатар хотноо 6 сарын 4-нөөс 10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссаратын бүсийн чуулганд тус яамнаас төлөөлөгч оролцож дүрвэгсдийн аюулгүй байдлыг хангах, тэдэнд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх асуудлаар санал солилцсон.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилтуудыг үндсэнд нь хэрэгжүүлж, 2004 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө хүчин чармайлт гарган ажиллалаа.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР